**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА**

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

**Ховд аймгийн Зэрэг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**Аудитын код: ХОА-2023/135/НА/-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Ховд хот<br>2023 он | Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Утас: 70433061<br>Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас:70432545<br>Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn<br>Гэрэлт Хөхийн тэнцвэр Аудит ХХК-ны Ховд дахь салбар<br>Аудитор: Д.Хишгээ<br>Утас: 70432545<br>цахим хаяг: hishgee.da @ gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ........ 3
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН** ........ 4
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ........ 9
**4. АУДИТЫН ТАЙЛАН** ........ 12
**4.1 Ерөнхий зүйл** ........ 12
**4.2 Материаллаг байдал** ........ 13
**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ........ 13
**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ... 13
**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ........ 13
**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ........ 13
**4.5.1 Завсрын аудитын талаар** ........ 13
**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй** ........ 14
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ........ 14
**5.1 Төлбөрийн ак** ........ 14
**5.2 Албан шаардлага:** ........ 13
**5.3 Зөвлөмж** ........ 14
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ........ 14

**Товчилсонүгийнжагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2023.02.08 № 02/17

танай ____________-ны №____________-т

ХОВД АЙМГИЙН ЗЭРЭГ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Ц.ЖИГДБАЯР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Зэрэг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэхбайгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Боловсролын салбар төсвийн шинэчлэлийн хүрээнд сургуулийн санхүүгийн эрх мэдэл, хувьсах зардал, сургуулийн бүтэц, хэв шинжийн шинэчлэл, сургалтын чанарт суурилсан цалин урамшууллын тогтолцоог бий болгосон байна.

Багш нарын цалинг ТҮ-5 ангиллаар олгосон, хувьсах зардлын тухайд багшийн эрүүл мэндийн үйлчилгээ, дата хэрэглээний зардал, хичээл практикийн зардал, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн зардлыг тусгаж, төлөвлөх, зарцуулах аргачлалыг Засгийн газрын 2022 оны 91 дугаар тогтоолоор баталж мөрдсөн байна.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Цэцэрлэг нь үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, Суралцагчийн хөгжил, хамгаалал, Багш, ажилтны тасралтгүй хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа, Сургалтын орчин бүрдүүлэлт, Удирдлагын манлайлал, менежмент, Сургалтын байгууллагын талаарх хэрэглэгчийн сэтгэл ханамж гэсэн

зургаан шалгуураар үнэлэхэд 4-р түвшинд үнэлэгдэж жилийн эцэст 7,986,600 төгрөгийн нэмэлт урамшуулал авсан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **28,274,263.2** | **46,401,789.9** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | 10,820,357.0 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | 10,820,357.0 |
| **3122** | **Гадаад валют** | - | 10,820,357.0 |
| 31221 | Төрийн сангийн харилцах | - | 10,820,357.0 |
| **33** | **АВЛАГА** | 337,049.2 | 387,294.9 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 337,049.2 | 387,294.9 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 27,937,214.0 | 35,194,138.0 |
| **354** | **Хангамжийн материал** | 27,937,214.0 | 35,194,138.0 |
| 35420 | Аж ахуйн материал | 10,662,712.0 | 10,594,712.0 |
| 35460 | Хүнсний материал | 4,019,340.0 | 2,529,950.0 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 13,255,162.0 | 22,069,476.0 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **572,862,547.5** | **724,870,030.0** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 572,862,547.5 | 724,870,030.0 |
| **392** | **Биет хөрөнгө** | 565,470,547.5 | 717,478,030.0 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 679,935,192.7 | 857,684,696.7 |

| | | | |
|---|---|---|---|
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (185,780,242.2) | (202,101,420.9) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 183,432,442.9 | 191,980,142.9 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (129,702,921.8) | (144,027,539.0) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 45,953,678.5 | 46,321,678.5 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (34,241,505.8) | (37,325,306.2) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 13,645,357.0 | 9,553,289.0 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (10,437,232.2) | (7,273,289.3) |
| 39217 | Ном | 2,665,778.3 | 2,665,778.3 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 7,392,000.0 | 7,392,000.0 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 7,392,000.0 | 7,392,000.0 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **601,136,810.7** | **771,271,819.9** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **682,648.3** | **67,540.0** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 682,648.3 | 67,540.0 |
| **413** | **Өглөг** | 682,648.3 | 67,540.0 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 675,991.3 | 67,540.0 |
| **4136** | **Бусад өглөг** | 6,657.0 | - |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 6,657.0 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **600,454,162.4** | **771,204,279.9** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 600,454,162.4 | 771,204,279.9 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 112,323,962.0 | 112,323,962.0 |
| 51101 | Өмч: - төрийн | 112,323,962.0 | 112,323,962.0 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 454,714,964.4 | 626,746,062.9 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 454,714,964.4 | 455,995,945.4 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 170,750,117.5 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 33,415,236.1 | 32,134,255.1 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **601,136,810.7** | **771,271,819.9** |

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **492,021,685.0** | **734,819,318.0** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **22,748,015.0** | **188,041,918.0** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 22,748,015.0 | 188,041,918.0 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 22,748,015.0 | 188,041,918.0 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 22,748,015.0 | 188,041,918.0 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **469,273,670.0** | **546,777,400.0** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 427,901,100.0 | 474,133,700.0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 474,133,700.0 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 427,901,100.0 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5,631,570.0 | - |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 157,000.0 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,474,570.0 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 35,741,000.0 | 72,643,700.0 |

| | | | |
|---|---|---|---|
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 35,741,000.0 | 72,643,700.0 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **531,270,978.7** | **564,069,200.5** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **531,270,978.7** | **564,069,200.5** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 475,553,338.7 | 558,877,900.5 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 314,834,933.0 | 364,713,525.0 |
| 210101 | Үндсэн цалин | 201,135,100.0 | 270,201,225.0 |
| 210102 | Нэмэгдэл | 92,013,433.0 | 83,843,622.0 |
| 210104 | Урамшуулал | 21,686,400.0 | 10,668,678.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 44,147,800.0 | 45,813,278.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31,403,478.5 | 31,201,760.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,189,230.4 | 3,667,265.8 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,548,024.3 | 2,920,372.6 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 637,006.0 | 722,948.1 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,370,060.8 | 7,300,931.5 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 34,161,000.0 | 49,805,400.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,360,500.0 | 2,760,500.0 |
| 210302 | Түлш, халаалт | 27,300,000.0 | 41,544,400.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,500,500.0 | 5,500,500.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 23,675,605.5 | - |
| 210401 | Бичиг хэрэг | 66,700.0 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 593,800.0 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 88,400.0 | - |
| 210404 | Ном, хэвлэл | 76,800.0 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 678,432.0 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 22,171,473.5 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 15,492,305.0 | 51,363,433.0 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,327,515.0 | - |
| 210502 | Хоол, хүнс | 12,449,490.0 | 51,195,433.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 715,300.0 | 168,000.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,740,000.0 | 180,000.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,160,000.0 | - |
| 210604 | Урсгал засвар | 1,580,000.0 | 180,000.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,467,600.0 | 962,000.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,143,600.0 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.0 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 962,000.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 38,034,095.2 | 46,040,264.5 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 6,728,543.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,374,400.0 | 4,654,000.0 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 33,659,695.2 | 34,657,721.5 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 55,717,640.0 | 5,191,300.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 4,953,138.0 | 5,191,300.0 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 4,953,138.0 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 5,191,300.0 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 50,764,502.0 | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 50,764,502.0 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(39,249,293.7)** | **170,750,117.5** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(39,249,293.7)** | **170,750,117.5** |

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 112,323,962.0 | 34,281,201.1 | 492,403,784.4 | 639,008,947.5 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 1,560,473.7 | 1,560,473.7 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **112,323,962.0** | **34,281,201.1** | **493,964,258.1** | 640,569,421.1 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | (865,965.0) | - | (865,965.0) |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (39,249,293.7) | (39,249,293.7) |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **112,323,962.0** | **33,415,236.1** | **454,714,964.4** | 600,454,162.4 |
| D01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **112,323,962.0** | **33,415,236.1** | **454,714,964.4** | 600,454,162.4 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 1,280,981.0 | 1,280,981.0 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **112,323,962.0** | **33,415,236.1** | **455,995,945.4** | 601,735,143.4 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | (1,280,981.0) | - | (1,280,981.0) |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 170,750,117.5 | 170,750,117.5 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **112,323,962.0** | **32,134,255.1** | **626,746,062.9** | 771,204,279.9 |

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **469273670.0** | **546777400.0** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **469273670.0** | **546777400.0** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 427901100.0 | 474133700.0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 0.0 | 474133700.0 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 427901100.0 | 0.0 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5631570.0 | 0.0 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 157000.0 | 0.0 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5474570.0 | 0.0 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 35741000.0 | 72643700.0 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 35741000.0 | 72643700.0 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **469273670.0** | **535957043.0** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **469273670.0** | **535957043.0** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **413556030.0** | **530765743.0** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 313294698.0 | 363241600.0 |
| 210101 | Үндсэн цалин | 196346898.0 | 263155920.0 |
| 210102 | Нэмэгдэл | 95261400.0 | 80472756.0 |
| 210104 | Урамшуулал | 21686400.0 | 19612924.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 44147800.0 | 47943900.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31067000.0 | 32676700.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3270200.0 | 3773200.0 |

| | | | |
|---|---|---|---|
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2616100.0 | 3081900.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 654200.0 | 749000.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6540300.0 | 7663100.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 34161000.0 | 49805400.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1360500.0 | 2760500.0 |
| 210302 | Түлш, халаалт | 27300000.0 | 41544400.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5500500.0 | 5500500.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1758432.0 | 0.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 121500.0 | 0.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 568000.0 | 0.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 99800.0 | 0.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 69400.0 | 0.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 678432.0 | 0.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 221300.0 | 0.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 12545000.0 | 49706043.0 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 306200.0 | 0.0 |
| 210502 | Хоол, хүнс | 11545500.0 | 49706043.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 693300.0 | 0.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1580000.0 | 180000.0 |
| 210604 | Урсгал засвар | 1580000.0 | 180000.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 900.0 | 0.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 900.0 | 0.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2467600.0 | 962000.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2143600.0 | 0.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324000.0 | 0.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 0.0 | 962000.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3600600.0 | 18926800.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 0.0 | 13226800.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3600600.0 | 5700000.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **55717640.0** | **5191300.0** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 4953138.0 | 5191300.0 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 4953138.0 | 0.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 0.0 | 5191300.0 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 50764502.0 | 0.0 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 50764502.0 | 0.0 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **0.0** | **10820357.0** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 0.0 | 10820357.0 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 0.0 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 0.0 | 10820357.0 |

## 2.5 Төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 546777400.0 | 535957043.0 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 546777400.0 | 535957043.0 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 541586100.0 | 530765743.0 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 363241600.0 | 363241600.0 |
| 210101 | Үндсэн цалин | 289519000.0 | 263155920.0 |
| 210102 | Нэмэгдэл | 63906100.0 | 80472756.0 |
| 210104 | Урамшуулал | 9816500.0 | 19612924.0 |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 47943900.0 | 47943900.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32676700.0 | 32676700.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3773200.0 | 3773200.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3081900.0 | 3081900.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 749000.0 | 749000.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7663100.0 | 7663100.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 49805400.0 | 49805400.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2760500.0 | 2760500.0 |
| 210302 | Түлш, халаалт | 41544400.0 | 41544400.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5500500.0 | 5500500.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 60526400.0 | 49706043.0 |
| 210502 | Хоол, хүнс | 60526400.0 | 49706043.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 180000.0 | 180000.0 |
| 210604 | Урсгал засвар | 180000.0 | 180000.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 962000.0 | 962000.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 962000.0 | 962000.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 18926800.0 | 18926800.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13226800.0 | 13226800.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5700000.0 | 5700000.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 5191300.0 | 5191300.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 5191300.0 | 5191300.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5191300.0 | 5191300.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 546777400.0 | 546777400.0 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 474133700.0 | 474133700.0 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 474133700.0 | 474133700.0 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 72643700.0 | 72643700.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 72643700.0 | 72643700.0 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **10,820,357.00** |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хүүхдэд ээлтэй эрүүл аюулгүй орчин бүрдүүлж өдөр тутмын хичээл үйл ажиллагааг чанартай зохион байгуулж, хүүхдийн хөгжилд ахиц гарган багш ажилчид харилцаа хандлагаар манлайлан эцэг эх асран хамгаалагчийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэн хамтран ажиллах үндсэн зорилготойгоор 8 бүлэг 190 гаруй хүүхэд 28 багш ажилтантайгаар СӨБ-ийн үйл ажиллагааг чанар хүртээмжтэй хүргэн ажилласан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хөдөлмөрийн тухай, Боловсролын тухай, сургуулийн өмнөх боловсролын тухай, Төрийн албаны тухай, Төсвийн тухай багц, Төрийн хэмнэлтийн тухай, Шилэн дансны тухай хууль , Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,Бусад хууль тогтоомжуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

**Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон.**

Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай 91 дугаар тогтоол, Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээ тогтоох 107-р тогтоол,МУ-ын БШУ-ны сайдын А/122 тушаал,МУЗГазрын 192 дугаар тогтоол,Сангийн сайдын 120 дугаар тушаал,МУЗГазрын 252 дугаар тогтоолыг тайлант онд мөрдөж ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна

Дотоод аудитаудиторынчиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүйгэж үзлээ

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ховд аймгийн Зэрэг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэлмөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэнтус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсонбайна *.*

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Ховд аймгийн Зэрэг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийнбодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 170.1 сая төгрөгөөр буюу 28.3 хувиар *өссөн* байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| **Үзүүлэлт** | **Эхний үлдэгдэл** | **Эцсийн үлдэгдэл** | **Өөрчлөлт** |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | 10,820.4 | (10,820.4) |
| Авлага | 337.0 | 387.3 | (50.3) |
| Бараа материал | 27,937.2 | 35,194.1 | (7,256.9) |
| Үндсэн хөрөнгө | 572,862.5 | 724,870.0 | (152,007.5) |
| **Нийт хөрөнгө** | **601,136.7** | **771,271.8** | **(170,135.1)** |
| Өр төлбөр | 682.6 | 67.5 | 615.1 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 600,454.1 | 771,204.3 | (170,750.2) |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **601,136.7** | **771,271.8** | **(170,135.1)** |

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө 10,820.4, бараа материал 7,256.9, үндсэн хөрөнгө 152,007.5, Засгийн газрын оролцоо Эздийн өмч 170,750.2 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 546,8 сая, нийт зарлагыг 546,8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 72,6 сая төгрөгөөр өсгөж баталсан байна. Энэ ньМУЗГ-ын 2022 оны 91 тоот тогтоолоор хувьсах зардлын санхүүжилтийг хүүхэд өдрөөр хянаж, төсвийн санхүүжилтийг гүйцэтгэлээр нь тооцож, батлагдсан хуваарьт нийцүүлэн сар бүр сургалтын байгууллагад олгож байгаатай холбоотой байна.

Нэг хүүхдэд ногдох зардлын дундаж нормативаар олгох санхүүжилтийн гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр хянаж хагас, бүтэн жилээр тооцон, зохих өөрчлөлтийг тусган төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчийн шийдвэрээр санхүүжүүлэх болсонтой холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 72,6 сая төгрөгөөр*нэмэгдүүлж* тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 535,9 сая төгрөгийг улс, орон нутгийн төсвөөсбүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 546,8 сая төгрөгийн санхүүжилт олгож, Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 535,9 сая төгрөг буюу 98,0хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2101 | 363,241.60 | 363,241.60 | - | 100 |
| 2 | 2102 | 47,943.90 | 47,943.90 | - | 100 |
| 3 | 2103 | 49,805.40 | 49,805.40 | - | 100 |
| 4 | 2105 | 60,526.40 | 49,706.00 | - | 100 |
| 5 | 2108 | 1,142.00 | 1,142.00 | - | 100 |
| 6 | 2109 | 18,926.80 | 18,926.80 | - | 100 |
| 7 | 213209 | 5,191.30 | 5,191.30 | | |
| | **Дүн** | **546,777.40** | **535,957.00** | **-** | **100** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Нэмэлт төсөвтэй холбоотой ямар нэгэн гүйлгээ гараагүй болно.

### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 4 хөтөлбөрийн 60 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

*Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт*

/мянган төгрөгөөр/

| № | Хөтөлбөр | Хэрэгжих хугацаа | Хүрэх үр дүн | Хэрэгжилтийн явц | Зарцуулах төсөв | Зарцуулсан |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Монгол хэл бичиг | 2021-2024 | Монгол хэлний хэрэглээ нэмэгдэнэ,эх хэлээ хайрлах дээдлэх үзэл төлөвшинө.Бүх нийтийн монгол бичгийн мэдлэг дээшилнэ. | 4 зорилтын хүрээнд 10 төрлийн ажил зохион байгуулсан. Биелэлтийн хувь 80.7 | | |
| 2 | Чадварлаг багш, оюутан, сурагч | 2021-2024 | Баруун бүсийн боловсролын салбарын тулгамдсан асуудлыг үе шаттай шийдвэрлэх гарч бий болсон байна, залуу багш нарын сайн дурын байгууллагын ажиллагаа идэвхжсэн байна. | 8 зорилтын хүрээнд 30 төрлийн сургалт үйл ажиллагаанд оролцож, тодорхой ажлуудыг зохион байгуулсан Биелэлтийн хувь 80 | | |
| 3 | Тогтвортой хөгжлийн боловсрол | 2021-2024 | Хүүхэд багачууд багаасаа өөрийн онцлог сонирхол, ирээдүйн хөгжилд нийцсэн, ажил мэргэжлийн чиг баримжаатай суралцах боломж нэмэгдэнэ | 3 зорилтын хүрээнд 8 ажил зохион байгуулсан Биелэлтийн хувь 89 | | |
| 4 | Чанартай боловсрол | 2021-2024 | Мэдлэг ойлголт тасралтгүй эзэмшинэ. | 4 зорилтын хүрээнд 12 төрлийн ажил зохион байгуулсан. Биелэлтийн хувь 85 | | |

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд аймгийн Зэрэг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл,түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах Үндсэн хөрөнгөтэй холбоотой өгсөнзөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлт Хөхийн тэнцвэр Аудит ХХК-ны Ховд аймаг дахь салбарын захирал, аудитор Д.Хишгээ 2023 оны 1 дугаар сарын 28-нээс 2023 оны 2 дугаар сарын06–ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2023 оны 01 дүгээр сарын 25 өдрийн А/1 албан бичгээр ирүүлсэн боловч 2023 оны 01 дугаар сарын 25-ны өдрийн А/01 тоотоор тайлангаа ирүүлсэн.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр  Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны3-р улирлын нийт орлого 357,1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 7.1 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогоор шинэчлэн тогтоолоо.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Зэрэг  сумын Хүүхдийн цэцэрлэгт нь энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан тэргүүн дэд, дэд, орлогч дарга, 7 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 10 дугаар зүйлд заасан цалин хөлс, нэмэгдэлтэй холбоотой заалтууд хамаарахгүй байна.

8 дугаар зүйлд заасан дүрэмт хувцас, 9 дүгээр зүйлд заасан албан ,11 дүгээр зүйлд заасан нэг удаагийн мөнгөн тэтгэмж ,12 дугаар зүйлд заасан бусад хангамж ,13 дугаар зүйлд заасан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, 14 дүгээр зүйлд заасан цахим худалдан авалт, 15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээтэй  холбоотой ямар нэгэн зардал гараагүй бйна.

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 119 мэдээллээс хугацаандаа оруулсан 119  мэдээлэлийг шилэн дансны сайтад байршуулсан байна.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус сургуульд 2022 оны 11 сард Төрийн аудитын баг завсрын аудит хэрэгжүүлэхэд төсвийн ,зарцуулалтад тавих дотоод хяналт өмнөх онуудаас сайжирсан ололттой байна гэж дүгнэж зөрчил илрээгүй байна.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нэг  зөвлөмж өгөгдсөнийг бүрэн  биелүүлжээ.

*Хүснэгт 4Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | | | | | |
| Зөвлөмж | 1.0 | 600.0 | 1.0 | 600.0 | 100.0 |
| Нийт дүн | 1.0 | 600.0 | 1.0 | 600.0 | 100.0 |

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй**

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 84009,6 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс, 84009,6 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

**5.1 Зөвлөмж**

**1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

***<u>Илрүүлэлт</u>:***

Тус цэцэрлэгийн үндсэн хөрөнгийн бүртгэлд ашиглах хугацаа дууссан 173 нэр төрлийн 82492,6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө байгаа нь Төсвийн тухай хуулийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; /Төсвийн төвлөрүүлэн захирагчид өгөх/, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.1-т "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно." зөрчсөн байна.

***<u>Өгсөн зөвлөмж</u>:*** Өөрийн эзэмшилд байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, ашиглах хугацаа нь дууссан дээрх хөрөнгийг ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлж ашиглах, ашиглах боломжгүй хөрөнгийг актлаж устгаж эдийн засгийн хувьд үр ашигтай байхаар шийдвэрлэх

### *2 . Зардалтай холбоотой асуудал*

***<u>Илрүүлэлт</u>:***

210901 Бараа үйлчилгээний бусад зардлаас хоолны зардал 1517097 төгрөг гаргасан байгаа нь Сангийн сайдын Зардлын эдийн засгийн ангилал батлах тухай 2021-10-29-ны 190 тоот тушаалтай нийцээгүй байна

***<u>Өгсөн зөвлөмж</u>:***

Батлагдсан төсөвт зардлаа зардлын зүйл ангиар үнэн зөв бүртгэж тайлагнах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийнаудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс |
|---|---|---|

[1]Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 2022 оны үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийн тайланд 173 ш 82492625.99 төгрөгний тэг үлдэгдэлтэй үндсэн хөрөнгө байна. | 1 | 82492.6 | 1 | 82492.6 |
| 210901 Бараа үйлчилгээний бусад зардлаас хоолны зардал 1517097төгрөг гаргасан | 1.0 | 1,517.0 | 1.0 | 1,517.0 |
| Зөрчлийн дүн | **2** | **84009.6** | **2** | **84009.6** |

засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно." зөрчсөн байна.

***Өгсөн зөвлөмж:*** Өөрийн эзэмшилд байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, ашиглах хугацаа нь дууссан дээрх хөрөнгийг ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлж ашиглах, ашиглах боломжгүй хөрөнгийг актлаж устгаж эдийн засгийн хувьд үр ашигтай байхаар шийдвэрлэх

***2 . Зардалтай холбоотой асуудал***

***Илрүүлэлт:***

210901 Бараа үйлчилгээний бусад зардлаас хоолны зардал 1517097 төгрөг гаргасан байгаа нь Сангийн сайдын Зардлын эдийн засгийн ангилал батлах тухай 2021-10-29-ны 190 тоот тушаалтай нийцээгүй байна

***Өгсөн зөвлөмж:***

Батлагдсан төсөвт зардлаа зардлын зүйл ангиар үнэн зөв бүртгэж тайлагнах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийнаудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс Зөвлөмж | |
|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 2022 оны үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийн тайланд 173 ш 82492625.99 төгрөгний тэг үлдэгдэлтэй үндсэн хөрөнгө байна. | 1 | 82492.6 | 1 | 82492.6 |
| 210901 Бараа үйлчилгээний бусад зардлаас хоолны зардал 1517097төгрөг гаргасан | 1.0 | 1,517.0 | 1.0 | 1,517.0 |
| Зөрчлийн дүн | **2** | **84009.6** | **2** | **84009.6** |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР: Д.ХИШГЭЭ

13

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР: Д.ХИШГЭЭ